

ЮНЕСКО-ИЙН ДЭЛХИЙН БАГА ХУРАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ

Эх Дэлхийнхээ төлөө суралцахуй.

Тогтвортой байдлын төлөө үйлдэхүй

ТХБ-2030



Тогтвортой хөгжлийн боловсролын Берлины тунхаглал

Удиртгал

1. Засгийн газрууд, олон улсын, засгийн газар хоорондын ба төрийн бус байгууллагууд, иргэний нийгэм, залуучууд, эрдэм судлалын нийгэмлэгийнхэн, бизнесийн салбарынхан болон багшлахуй ба суралцахуйн хүрээний бүх оролцогчид бид ЮНЕСКО-оос ХБНГУ-ын Боловсрол, судалгааны яам болон зөвлөх түншээр ажилласан ЮНЕСКО-ийн Германы комисстой тус тус хоршин ажиллаж, 2021 оны 5 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд онлайнаар зохион байгуулсан Тогтвортой хөгжлийн боловсролын Дэлхийн бага хурлаар энэхүү тунхаглалыг батлав.
2. Дэлхий дахинд нүүрлээд байгаа гүн гүнзгий харилцан уялдаатай сорилтуудыг, ялангуяа манай гаригийн амьдралд аюул занал учруулж буй уур амьсгалын хямрал, биологийн төрөл зүйлийн олон янз байдлын массын алдагдал, хүрээлэл орчны бохирдол, халдварт цар тахлын өвчнүүд, туйлын ядуурал, тэгш бус байдал, хүчирхийллийн зөрчил мөргөлдөөн, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн бусад асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байгаад бид итгэл үнэмшил нэгтэй байна. Ковид-19 цар тахлын улмаас улам бүр хурцдаж буй хойш тавих боломжгүй эдгээр сорилтууд нь биднийг өөр хоорондоо болон байгальтайгаа илүү шударга харьцаж, инклюзив оролцоотой, анхаарал халамжтай, эв нийцтэй харилцан хамааралд суурилсан тогтвортой хөгжлийн замд оруулах суурь хувирган өөрчлөлт шаардлагатай байгааг бидэнд ойлгуулж байна.

With the advisory support of:



3. Боловсрол бол сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзлийг эерэгээр өөрчлөх хүчирхэг хэрэгсэл бөгөөд тэр нь хөгжлийн замналыг гариг дэлхийдээ хор хохирол учруулах эдийн засгийн өсөлтөд зөвхөн баримжаалахгүйгээр манай гаригийн хил хязгаар дахь бүх зүйлийн сайн сайхан байдлыг хангах замаар эдийн засаг, нийгэм, хүрээлэл орчны тогтвортой хөгжлийн бүхий л хэмжүүрийг интеграцчилахад тусалж чадна гэдэгт бид бат итгэлтэй байна.
4. ТХЗ 4.7-д аргамжигдаж, ТХ-ийн бүх 17 зорилгыг амжилтад хүргэх гол хэрэгсэл болох Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) нь хүн бүрийг тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг гүйцэтгэх зуучлагч болоход нь тэдэнд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагын хувирган өөрчлөлтийн үндэс суурь мөн гэдэгт бид итгэл дүүрэн байна. ТХБ нь суралцагчдад танин мэдэхүйн ба танин мэдэхүйн бус чадваруудыг хөгжүүлэх, тухайлбал, шүүмжлэлт сэтгэлгээ, хамтран ажиллах цогц чадамжууд, асуудал шийдвэрлэх, төвөгтэй байдал ба эрсдэлийг даван туулах, тэсвэр тэвчээрийг бий болгох, системтэй, бүтээлчээр сэтгэн бодох зэрэг чадваруудыг хөгжүүлэх, түүнчлэн “ТХЗ 4: Боловсрол 2030”-д тодорхойлсны дагуу тэд чанартай боловсрол эзэмших эрхээ бүрэн хангуулснаар тэдэнд иргэнийхээ хувьд үйл хэрэгтээ хариуцлагатай хандах боломжийг олгодог. ТХБ нь байгальд хүндэтгэлтэй хандах, мөн хүний эрхийг хангах, ардчиллыг эрхэмлэх, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, үл алагчилах байдал, жендэрийн тэгш байдлыг хангахад суурилсан байх ёстой гэдэгт бид итгэдэг. Нэмж дурдахад, ТХБ нь соёл хоорондын харилцан ойлголцол, соёлын олон янз байдал, хүчирхийлэлгүй энх тайванч байх соёл, инклюзив оролцоо хийгээд хариуцлагатай, идэвхтэй дэлхийн иргэн гэсэн ойлголтуудыг сурталчлах ёстой.
5. Бодлогыг нарийвчлан уялдуулах, суралцахуйн орчныг хувирган өөрчлөх, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхыг бий болгох, залуучуудад боломж, эрх мэдэл олгож, тэднийг дайчлах, орон нутгийн түвшний үйлийг хурдасгах чиглэлээр ойрын 10 жилийн хугацаанд баримтлах үндсэн баримт бичиг болох "ТХБ-2030" шинэ Үйлийн хүрээ болон Замын зураглалыг бид сайшаан дэмжиж байна.

Бидний амлалт

6. Бид өөрсдийн бүрэн эрхийнхээ болон хариуцлагынхаа хүрээнд өөрсдийн хэрэгцээ, чадавх, боломжит нөөц, үндэсний тэргүүлэх чиглэлийг харгалзан дараах зүйлийг амлаж байна.

With the advisory support of:



- a. Тогтвортой хөгжлийн бүх талын асуудлын харилцан хамаарал, уялдаа холбоог хүлээн зөвшөөрдөг ТХБ-ын бүхэл бүтэн, цогц байх хэтийн харааг хадгалахын зэрэгцээ хүрээлэл орчин ба уур амьсгалын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрийн цөм хэсэг байхаар ТХБ-ыг бүх түвшний боловсролын тогтолцооны үндсэн элемент болгон баталгаажуулах;
- b. ТХБ-ыг бага насны хүүхдийн боловсролоос дээд боловсрол, насанд хүрэгчдийн боловсрол, түүний дотор техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС) зэрэг боловсролын бүх түвшинд, мөн албан бус боловсрол, амьдрах орноос суралцахуйд тус тус интерацчилах, ингэснээр бүх хувь хүнийг насан туршдаа, амьдралын өргөн хүрээнд тогтвортой хөгжлийн төлөө суралцах өргөн боломжоор хангах;
- c. Хувирган өөрчлөлтийн хувь хүний болон нийгмийн хэмжүүрүүдийн хүрээнд танин мэдэхүйн ур чадвар, нийгэмшил ба сэтгэл хөдлөлийн суралцахуй, үйл гүйцэтгэх цогц чадамжуудыг хамтад нь тодотгон авч үзэж хэрэгжүүлэх, тогтвортой хөгжил, тэгш байдал, хүний эрхийг хүндлэх зарчим, түүнчлэн эдийн засаг, нийгмийн тогтолцооны түвшин дэх суурь бүтцийн болон соёлын өөрчлөлтүүд, мөн тэдгээр өөрчлөлтөд хүргэхэд шаардагдах улс төрийн үйл ажиллагааг тус тус хөхиүлэн дэмжих;
- d. Судалгаа, нотолгоонд суурилсан бодлого боловсруулалт, ардчилсан шийдвэр гаргалт, уугуул ард түмний мэдлэгийг хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг үзүүлэх, хүмүүс болон гараг Дэлхийн сайн сайханы төлөөх энэрэхүйд төвлөрсөн тогтвортойгоор хувиран өөрчлөгдөж буй эдийн засгийг дэмжих, ирээдүйд тохиолдож болзошгүй дэлхий нийтийг хамарсан хямралыг тэсвэрлэх чадвар болон түүнд бэлэн байх байдлыг дээшлүүлэхийн тулд шинжлэх ухааны мэдлэг ба өгөгдөл хуваалцах боломжийг хөхиүлэн дэмжих замаар нийгмээ дахин загварчилахад ТХБ-ын хүчийг ашиглах
- e. Сургалтын байгууллага нь идэвхтэй байр суурь бүхий иргэний оролцоо, үл алагчилагдах шудрага байдал, жендэрийн тэгш байдал, эрүүл мэнд, байгаль ба хүрээлэл орчинтойгоо холбогдсон байдал, эрчим хүчний үр ашигтай, тогтвортой хэрэглээг хүндэтгэдэг амьд лаборатори болж, улмаар суралцахуй нь туршилт, бодит үйлд баримжаалсан, хам нөхцөл, соёлын онцлогт нийцэн нутагшсан, суралцагчид сурч мэдсэн зүйлээрээ амьдардгийг, амьдарч буй зүйлээсээ сурч мэддэгийг тооцдог болсон үед л суралцагчид болон сургуулийн хамт олон нь ардчилсан оролцоогоор дамжин тогтвортой хөгжилд бүрэн утгаараа бүтээлчээр татагдан оролцдогийг хүлээн зөвшөөрдөг байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлагыг сурталчлан нэвтрүүлэх;

With the advisory support of:



- f. Жижиг арлын хөгжиж буй улсуудын хувьд уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт өртөмтгий байдал өсөн нэмэгдэж байгаагаас шалтгаалан ТХБ-ыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал шаарддаг тул уур амьсгалын өөрчлөлтийг ТХБ-ын тэргүүлэх чиглэл гэж хүлээн зөвшөөрөх.
- g. ТХБ-ыг дэмжин урагшлуулахад багш нарын гүйцэтгэх шийдвэрлэх үүргийг хүлээн зөвшөөрч, боловсролын бүх түвшний багш нарын болон боловсролын салбарын бусад боловсон хүчний чадавхыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах, боловсролын хувирган өөрчлөлтөд зайлшгүй шаардлагатай салбар бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх;
- h. Технологиудын хүртээмж, хөгжүүлэлт, ашиглалтын хариуцлагатай, аюулгүй, үл алагчилсан шударга, инклюзив оролцоог хангасан, эрсдэл, ашиг тусын нарийн зөв үнэлгээ бүхий шүүмжлэлт сэтгэлгээ, тогтвортой байдлын зарчимд суурилсан, түүнчлэн ТХБ-д зориулсан нээлттэй боловсролын нөөцүүд, нээлттэй шинжлэх ухаан, боломжийн үнэтэй цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг таниулан сурталчилсан шинэ, дижитал болон "ногоон" технологийн боломжуудыг ашиглах;
- i. Залууст сурч боловсрох, иргэний нийгмийн үйл хэрэгт татагдан оролцох боломжийг нь бүрдүүлэн өгч, тэднийг хувь хүний болон нийгмийн хувирган өөрчлөлтийг хамтран бүтээгчийн хувьд ТХБ-д оролцох арга хэрэгсэл, цогц чадамжаар хангах замаар тогтвортой хөгжлийн өөрчлөлтийн зуучлагчид болох эрх мэдлийг олгож, тэднийг чадавхжуулах
- j. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, дүрвэгсэд, зөрчил мөргөлдөөн, хямрал, байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүс зэрэг хүнд нөхцөлд байгаа хүн амд тэдний хам нөхцөлд нь нийцсэн, гамшгийн үе дэх ТХБ-ыг тусгасан ТХБ-ын шинэлэг бодлого бүхий инклюзив оролцоот арга хандлагаар дамжуулан тэргүүлэх ач холбогдол өгөх;
- k. Мэдлэг, ур чадварын хүртээмжид жендэрийн тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байхыг онцолсон тогтвортой байдлын сорилтуудыг даван туулах, боломжит шийдлүүдийг гаргахдаа ТХБ-д илүү гүн гүнзгий үндэслэл бүхий бүхэл бүтэн цогц ойлголтыг бий болгохыг жендэрийн тэгш байдлыг хангах гол чиг шугам болгон баримтлах;
- l. ТХБ-ыг ядуурал, ялангуяа туйлын ядууралтай тэмцэхэд дайчилж, ТМБС болон хүний нэр төр, зохистой амьдрах эрхийг хангахуйц тогтвортой амьжиргааны ур чадвараар дамжуулан ядууралд өртөгчдөд хувь хүний болон нийгмийн эрэлт хэрэгцээг хангахуйц цогц чадамж эзэмшүүлэх;

With the advisory support of:



- m. Боловсролын яамд нь засаглалын бүх түвшинд тогтвортой хөгжилд үр нөлөө үзүүлдэг бусад бүх яамдтай хамтарч, Засгийн газрын бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхийн тулд Боловсролын болон Байгаль, хүрээлэл орчны яамд хоорондын хоршсон ажиллагаа төвтэй, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны нийгэмлэгүүд, бизнесийн сектор, залуучууд болон бусад бүх холбогдох хувь нийлүүлэгч бүлгүүдтэй ТХБ-ын чиглэлээр олон-салбар оролцсон, олон-шинжлэх ухааныг хамарсан хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;
- n. Боловсрол, хүрээлэл орчин, уур амьсгал, тогтвортой эдийн засаг болон бусад холбогдох хөгжлийн хөтөлбөрүүдийн цаашдын зохицол, уялдаа холбоог дэлхийн, бүс нутгийн болон үндэсний түвшинд нийцүүлэх, улмаар хүчин чармайлт нь харилцан бие биенээ дэмжин нөхөж ТХБ-ын үндсэн бүтцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байхаар янз бүрийн хувь нийлүүлэгчид хоорондын сүлжээг өргөжүүлэх;
- o. Ковид-19 ба түүнээс хойшх хугацаанд ТХБ-д хангалттай нөөцийг хуваарилж, түүний дотоодын болон олон улсын санхүүжилтийг хамгаалах, түүнчлэн хөгжиж буй орнуудын чанартай боловсролыг дэмжиж, залуучуудад боломж, эрх мэдэл олгон чадахжуулах замаар бүх нийгмийг илүү шударга, тогтвортой болгоход үзүүлэх боловсролын нөлөөг хүчирхжүүлэхэд олон улсын хөгжлийн байгууллагуудын хорших ажиллагааны гүйцэтгэх үүргийг чухалчлан авч үзэх;
- p. ТХБ-ын хэрэгжилт тасралтгүй сайжирч, хэнийг ч орхигдуулахгүй байхаар ТХБ-ын үнэлгээний системийг боловсронгуй болгон ТХБ-ын ахиц дэвшлийг хэрхэн үнэлэх талаарх судалгаануудыг өргөжүүлэн сайжруулахын тулд ТХБ-ийн бүх зорилгууд болон ялангуяа 4.7 товлосон зорилтын ерөнхий хяналт-шинжилгээний хам нөхцөл дэх ТХБ-ын ахиц дэвшлийн үнэлгээг хийх;

Цаашдын алхам

- 7. ТХБ-ыг тэргүүлэх Нэгдсэн үндэстний байгууллагын агентлаг болохынх нь хувьд ЮНЕСКО-г гишүүн орнуудтайгаа хоршин ажиллаж, энэхүү тунхаглалыг хэрэгжүүлэхэд ЮНИТВИН/ЮНЕСКО-ийн тэнхимүүд, ЮНЕСКО-ийн Холбоот сургуулиуд, ЮНЕСКО-д бүртгэгдсэн газар нутгууд зэрэг бусад сүлжээгээ дайчлан, хэрэгжилтийн ахиц дэвшилд тогтмол тойм үнэлгээгээр хангаж байхыг уриалж байна.

With the advisory support of:



8. Бид 2021 оны Нэгдсэн үндэстний байгууллагын Биологийн олон янз байдлын бага хурал (COP 15), 2021 оны Нэгдсэн үндэстний байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурал (COP 26) зэрэг чухал үйл явдлуудыг угтан дэлхий нийтийн, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн түвшний үйл явцаар дамжуулан энэхүү тунхаглал, түүний заалтуудыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг амлалтыг хүлээж байна.
9. Хүмүүс болон гараг Дэлхийн төлөө хувирган өөрчлөх суралцахуй нь бидний болон хойч үеийнхний амьд үлдэж, оршин тогтнохын зайлшгүй хэрэгцээ юм. Гараг дэлхийнхээ төлөө суралцаж, ажиллах цаг нь иржээ.

With the advisory support of:

